



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 10 дугаар сарын 6-ны өдөр

Улаанбаатар хот

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1-20.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.3.9 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.8 дахь хэсэг, 50 дугаар зүйлийн 50.4 дэх хэсэг, 58 дугаар зүйлийн 58.1.4 дэх заалт, 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсгийн хувь нийлүүлэгч гэснийг хувьцаа эзэмшигч гэж, 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 28.1, 28.3, 28.10 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 29.1-29.4 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 30.1, 30.2, 30.4 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.3.4, 31.3.5 дахь заалт, мөн зүйлийн 31.6 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 38.2.2 дахь заалт, 49 дүгээр зүйлийн 49.1.3 дэх заалтын хувь нийлүүлэгчдийн гэснийг хувьцаа эзэмшигчдийн гэж, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн хувь нийлүүлэгчтэй гэснийг хувьцаа эзэмшигчтэй гэж, 53 дугаар зүйлийн 53.1.1 дэх заалтын хувь нийлүүлэгчийн гэснийг хувьцаа эзэмшигчийн гэж, мөн зүйлийн 53.8 дахь хэсгийн хувь нийлүүлэгчид гэснийг хувьцаа эзэмшигчид гэж, 63 дугаар

зүйлийн 63.1.1 дэх заалтын хувь нийлүүлэгчдэд гэснийг хувьцаа эзэмшигчдэд гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Компанийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ